

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2025.01.06

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Доналд Трамп ерөнхийлөгчийн тангарагаа 1-р сарын 20-ны өдөр өргөнө.
- Майк Жонсон АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын даргаар сонгогдов. Энэхүү үйл явдал нь АНУ-ын Төлөөлөгчдийн танхимд Бүгд Найрамдахчуудын нөлөөг улам бататгаж байна.
- Биткоын 100,000 ам.долларыг давбал SOL, SUI, ICP, ENA өсөх магадлалтай
- БНХАУ-ын үйлдвэрлэлийн PMI 50.1 болж буурсан ч үйлчилгээний PMI 52.2 болж өсөв. Үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарын PMI үзүүлэлт 50 нэгжээс өндөр байгаа нь эдийн засаг эрчимжиж буйг илтгэнэ.

2025 он 01-р сарын 06

Dow Jones	42,732.13
S&P 500	5,942.50
Nasdaq	19,621.68
DAX	19,906.08
FTSE 100	8,223.98
S&P/ASX 200	8,259.50
HANG SENG	19,763.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.80%	0.37%	-4.28%	0.44%	14.06%	17.94%
S&P 500	1.26%	0.60%	-2.43%	1.03%	26.51%	27.06%
Nasdaq	1.77%	0.69%	-1.20%	1.61%	35.10%	31.37%

2025 оны 01 сарын 06-ны 11:00

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-0.59%	-0.02%	-2.35%	-0.02%	19.96%	24.82%
FTSE 100	-0.44%	1.27%	-1.02%	0.62%	6.95%	9.87%

2025 оны 01 сарын 06-ны 11:00

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.08%	0.23%	-1.99%	1.16%	10.21%	10.74%
Hang Seng	0.04%	-1.37%	-0.50%	-1.47%	19.54%	-15.87%

2025 оны 01 сарын 06-ны 11:00

S&P 500 индексийн  
2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Wells Fargo	6,500
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678



## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хоёр дахь жилдээ өндөр өсөв

Өнгөрсөн долоо хоногт баярын өдрүүд тохиож, S&P 500 индекс 0.66%, Nasdaq 0.99%, DJIA 0.73%-иар тус тус унасан гүйцэтгэлтэй байлаа. S&P 500 индекст багтах компаниудын энергийн салбарын хувьцаанууд өссөн ба технологийн ахулууд уналттай байсан ч Nvidia компани ганцаараа 3.24 хувиар өсөв.

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр S&P 500 23.84%-иар өссөнөөр хоёр дахь жилдээ 20%-иас дээш өсөж, сүүлийн 25 жилийн хамгийн хүчтэй хоёр жилийн өсөлтийг харууллаа. Мөн Nasdaq 29.81%-иар өссөнөөр найман жилийн хугацаанд зургаа дахь удаагаа 20%-иас дээш өслөө.

### Өсөлтөөр тэргүүлсэн компаниуд

1. Palantir (PLTR) 340.48%
2. Vistra (VST) 258%
3. Nvidia (NVDA) 171.17%

### 2025 оны эхний сарын хүлээлт

Гурав дахь жилдээ дараалан онцлох өсөлт үзүүлэх эсэх нь эдийн засгийн төлөвөөс ихээхэн хамаарах бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл эдийн засгийн эрүүл байдлыг тодорхойлох гол үзүүлэлт болно. Мөн эдгээр мэдээлэл нь Холбооны Нөөцийн банкны бодлогын хүүгийн ирээдүйн төлөвийг тодруулахад тусална. Өнгөрсөн сард тус банк 2025 оны инфляцын таамаглалаа өсгөж, хүү бууруулах бодлогодоо илүү болгоомжтой хандсанаар зах зээлд тодорхойгүй байдал үүсгэсэн юм.

Хөрөнгө оруулагчид эдийн засаг хэт хүчтэй байгааг харуулах ажлын байрны тайлангаас болгоомжилж байна. Учир нь шинэ ерөнхийлөгч Доналд Трампын засаг захиргааны үед инфляц дахин сэргэх магадлал нь оны эхэнд зах зээлд тулгарах гол эрсдэлүүдийн нэг гэж үзэж байна.

### График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

БНХАУ-ын эдийн засаг, болон хөрөнгийн зах зээлээ дэмжих бодлогын нөлөөгөөр 20224 онд Hang Seng индекс 17 орчим хувиар өслөө. Гэсэн ч цаашдаа дахин засгийн газраас дахин хүчтэй бодлого гаргахгүй бол 2025 онд хөрөнгийн зах зээл уналттай байх магадлалтай байна.

### Хятадын үйлдвэрлэлийн үзүүлэлт

Хятадын хөрөнгийн зах зээлд үйлдвэрлэлийн үзүүлэлт хүлээлтээс доогуур гарсан нь хөрөнгө оруулагчдын сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, хувьцааны үнэ уналтад оржээ. Шанхайн Хувьцааны Индекс 5.55%-иар, CSI 300 индекс 5.17%-иар буурсан бол Хонг Конгийн Hang Seng индекс 1.64%-иар унав.

Хятадын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гурав дахь сардаа өсөлттэй гарсан ч албан ёсны PMI үзүүлэлт 12-р сард 50.1 болж, 11-р сарын 50.3-аас буурсан нь эдийн засагчдын таамагт хүрсэнгүй. Харин барилга болон үйлчилгээний салбарын үйл ажиллагааг хэмждэг PMI үзүүлэлт 50-аас 52.2 болж нэмэгдэн хүлээлтээс давсан байна.

Үүний зэрэгцээ хувийн хэвшлийн Caixin Manufacturing PMI 12-р сард 50.5 болж, 11-р сарын 51.5-аас буурчээ. Энэ нь гурав дахь сардаа дараалан өсөлт үзүүлсэн ч эдийн засагчдын таамаглалд хүрсэнгүй. Эдгээр үзүүлэлтүүд нь Бээжингийн 9-р сараас хэрэгжүүлсэн эдийн засгийг дэмжих арга хэмжээнүүдийн дараах эдийн засгийн сэргэлтийг тодорхой хэмжээнд харуулж байгаа ч дотоод эрэлт сул, гадаад хүчин зүйлс таагүй хэвээр байгааг онцолжээ.

### 2024 онд

5-р сар: АНУ Хятадын цахилгаан автомашины тарифыг 100%-д хүргэж нэмэгдүүлэв.

9-р сар: Хятадын төв банк эдийн засгаа дэмжихийн тулд банкнуудын заавал байлгах нөөцийн хэмжээг 0.5%-аар бууруулав.

10-р сар: Хятад 800 тэрбум юаниар зах зээлээ дэмжих шийдвэр гаргав.

12-р сар: БНХАУ эдийн засгаа сэргээх зөөлөн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ гэдгээ зарлав.

### График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал

abliguan published on TradingView.com, Nov 25, 2024 12:10 UTC+8

HSIHSEI, 10 C119,307.34 H119,351.06 L119,102.70 C119,131.82 -98.15 (-0.51%)





ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД







































Хүснэгт 1: Энэ долоо хоногт зарлагдах онцлох мэдээнүүд

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ

гарах онцлох мэдээнүүд (GMT +8)

ДАВАА ГАРАГ (01/06)		ҮЙЛ ЯВДАЛ	ХҮЛЭЭЛТ
22:45	АНУ	S&P Global Services PMI (12 cap)	58.5
МЯГМАР ГАРАГ (01/07)			
23:00	АНУ	ISM Non-Manufacturing PMI (12 cap)	53.2
23:00	АНУ	ISM Non-Manufacturing Prices (12 cap)	58.2
ЛХАГВА ГАРАГ (01/08)			
23:30	АНУ	Газрын тосны нөөц (12 cap)	-1.178 сая
ПҮРЭВ ГАРАГ (01/09)			
Амарна	АНУ	Үндэсний өдөр	
03:00	АНУ	FOMC-ийн хурлын тэмдэглэл	
БААСАН ГАРАГ (01/10)			
21:30	АНУ	Хөдөө аж ахуйн бус ажлын байрны тоо (12 cap)	154 мянган хүн
21:30	АНУ	Ажилгүйдлийн түвшин (12 cap)	4.2%

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases							
		for the week beginning							
		January 06, 2025							
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
		    	        	          	          	      	          		
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>		© 2025 Earnings Whispers							